

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Увс аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2023/56/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
[www.audit.mn](#)
Улаангом хот
2023 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,
Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь
Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn
Аудитын менежер: М.Бат-Амгалан
Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn
Аудитор: Б.Одгэрэл
Утас: 86032989, Цахим хаяг: Odgerelb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан.....
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17. Факс: (976)70-45-33-17.
E-mail: uvs@audit.gov.mn

УВС АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН
ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ГАЗРЫН
ДАРГА, ХОШУУЧ З.АРИУНБАЯР
ТАНАА

2023.02.14 № УВА-2023/56/НА-СТА-ТШЗ
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Увс аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Увс аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

0200200718

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	62,432,620.63	60,721,580.21
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	128,000.00	128,000.00
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	128,000.00	128,000.00
31210	Төгрөг	128,000.00	128,000.00
31211	Төрийн сангийн харилцах	128,000.00	128,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	62,304,620.63	60,593,580.21
35100	Түүхий эд материал	21,423,485.00	24,378,145.01
35110	Тусгай зориулалттай материал	19,540,285.00	22,294,145.01
35130	Эм боох материал	1,883,200.00	2,084,000.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	4,576,608.50	3,751,888.20
35400	Хангамжийн материал	36,304,527.13	32,463,547.00
35410	Бичиг хэргийн материал	1,476,202.00	5,802,920.00
35420	Аж ахуйн материал	33,043,601.13	26,472,991.00
35460	Хүнсний материал	1,784,724.00	187,636.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,771,701,383.80	1,751,067,890.22
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,771,701,383.80	1,751,067,890.22
39200	Биет хөрөнгө	1,649,505,597.28	1,626,516,890.22
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,634,987,661.17	1,634,987,661.17
39202	Хуримтлагдсан элэгдэл	-108,941,090.76	-145,254,787.68
39203	Авто-тээврийн хэрэгсэл	176,313,888.91	124,701,388.91
39204	Хуримтлагдсан элэгдэл	-100,740,972.08	-57,443,749.80
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	117,003,567.13	105,461,019.74
39206	Хуримтлагдсан элэгдэл	-83,682,414.55	-54,028,447.56
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	31,337,190.00	33,830,063.33
39208	Хуримтлагдсан элэгдэл	-21,031,056.54	-19,995,081.89
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	4,258,824.00	4,258,824.00
39300	Биет бус хөрөнгө	122,195,786.52	124,551,000.00
39301	Програм хангамж	6,417,692.31	3,862,692.31
39302	Хуримтлагдсан элэгдэл	-6,217,905.79	-1,307,692.31
39303	Бусад биет бус хөрөнгө	121,996,000.00	121,996,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,834,134,004.43	1,811,789,470.43
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,834,134,004.43	1,811,789,470.43
51	Засгийн газрын хувь оролцоо	1,834,134,004.43	1,811,789,470.43
51100	Засгийн газрын оруулсан капитал	892,687,783.90	892,687,783.90
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	892,687,783.90	892,687,783.90
51200	Хуримтлагдсан үр дүн	397,468,354.94	375,123,820.94
51210	Өмнөх үеийн үр дүн	436,425,541.17	397,468,354.94
51220	Тайлант үеийн үр дүн	-38,957,186.23	-22,344,534.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	543,977,865.59	543,977,865.59
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,834,134,004.43	1,811,789,470.43

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	812,807,143.00	866,869,225.08
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	24,449,640.00	68,987,325.08
120	Нийтлэг татварын бус орлого	24,449,640.00	68,987,325.08
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	43,614,997.07
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	6,892,900.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	8,609,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	0.00	28,113,097.07
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	6,399,900.00	18,857,433.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	18,049,740.00	6,514,895.01
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	788,357,503.00	797,881,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	766,907,100.00	788,876,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	766,907,100.00	788,876,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	21,450,403.00	9,005,600.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,000,000.00	2,500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	17,135,403.00	0.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	315,000.00	6,505,600.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	851,764,329.23	889,193,264.27
21	УРСГАЛ ЗАРДАЛ	851,764,329.23	889,193,264.27
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	845,801,380.81	884,186,822.12
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	534,783,329.76	568,871,785.99
210101	Үндсэн цалин	350,278,356.20	367,162,519.39
210102	Нэмэгдэл	181,791,900.00	188,862,235.60
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,033,073.56	11,167,031.00
210104	Урамшуулал	1,680,000.00	1,680,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12,032,557.25	13,756,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12,032,557.25	13,756,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	105,348,966.57	119,449,995.86
210301	Гэрэл, цахилгаан	12,241,648.57	15,504,362.86
210302	Түлш, халаалт	79,751,760.00	79,751,860.00
210303	Цэвэр, бохир ус	13,355,558.00	24,193,773.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,366,591.00	32,305,432.13
210401	Бичиг хэрэг	2,482,700.00	3,361,182.00
210402	Тээвэр, шатахуун	15,776,410.00	17,421,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,093,141.00	4,203,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	377,000.00	151,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,637,340.00	1,445,300.00
210408	Бараа материал акталсны зардал	0.00	5,723,550.13
2105	Нормативт зардал	24,316,307.62	37,645,776.30
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,222,000.00	1,125,500.00
210502	Хоол, хүнс	19,920,265.62	33,731,161.00

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,174,042.00	2,789,115.30
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	58,837,968.00	24,947,300.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	117,500.00	155,900.00
210604	Урсгал засвар	58,720,468.00	24,791,400.00
2107	Томилолт, зочны зардал	1,030,000.00	1,310,600.00
210702	Дотоод албан томилолт	1,030,000.00	1,310,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,128,239.00	11,610,503.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,040,000.00	8,853,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	224,000.00	432,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	283,959.00	279,913.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	110,000.00	50,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	818,500.00	818,500.00
210807	Газрын төлбөр	1,651,780.00	1,175,890.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	77,957,421.61	74,288,528.84
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	949,800.00	0.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	77,007,621.61	74,288,528.84
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,962,948.42	5,006,442.15
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,192,000.00	2,810,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,192,000.00	2,810,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	770,948.42	2,196,442.15
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	455,948.42	2,161,442.15
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	315,000.00	35,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-38,957,186.23	-22,324,039.19
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	20,494.81
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	0.00	20,494.81
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-38,957,186.23	-22,344,534.00

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	788,357,503.00	813,383,800.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	15,501,900.00
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	15,501,900.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	15,501,900.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	6,892,900.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	8,609,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	788,357,503.00	797,881,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	766,907,100.00	788,876,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	766,907,100.00	788,876,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	21,450,403.00	9,005,600.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,000,000.00	2,500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	17,135,403.00	0.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	315,000.00	6,505,600.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	774,337,910.00	806,678,800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	774,337,910.00	806,678,800.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	768,374,961.58	801,672,357.85
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	534,783,329.76	568,871,785.99
210101	Үндсэн цалин	350,278,356.20	367,162,519.39
210102	Нэмэгдэл	181,791,900.00	188,862,235.60
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,033,073.56	11,167,031.00
210104	Урамшуулал	1,680,000.00	1,680,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12,032,557.25	13,756,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12,032,557.25	13,756,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	105,348,966.57	119,449,995.86
210301	Гэрэл, цахилгаан	12,241,648.57	15,504,362.86
210302	Түлш, халаалт	79,751,760.00	79,751,860.00
210303	Цэвэр, бохир ус	13,355,558.00	24,193,773.00
2104	Хангамж, бараа материалын зардал	24,906,423.00	26,865,600.00
210401	Бичиг хэрэг	2,475,532.00	3,179,900.00
210402	Тээвэр, шатахуун	14,776,410.00	17,421,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,093,141.00	4,203,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	377,000.00	301,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,184,340.00	1,760,200.00
2105	Нормативт зардал	21,334,020.00	32,993,973.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,222,400.00	859,900.00
210502	Хоол, хүнс	20,111,620.00	32,134,073.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	61,861,626.00	26,813,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,560,408.00	1,865,700.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	190,750.00	155,900.00
210604	Урсгал засвар	59,110,468.00	24,791,400.00

2107	Томилолт, зочны зардал	1,030,000.00	1,310,600.00
210702	Дотоод албан томилолт	1,030,000.00	1,310,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,128,239.00	11,610,503.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,040,000.00	8,853,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	224,000.00	432,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	283,959.00	279,913.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	110,000.00	50,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	818,500.00	818,500.00
210807	Газрын төлбөр	1,651,780.00	1,175,890.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	949,800.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	949,800.00	0.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,962,948.42	5,006,442.15
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,192,000.00	2,810,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,192,000.00	2,810,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	770,948.42	2,196,442.15
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	455,948.42	2,161,442.15
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	315,000.00	35,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	14,019,593.00	6,705,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	14,019,593.00	6,705,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	14,019,593.00	6,705,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	14,019,593.00	6,705,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	14,019,593.00	6,705,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-14,019,593.00	-6,705,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)		
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	128,000.00	128,000.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	128,000.00	128,000.00
100	Тохируулгын орлого, зарлагын зөрүү		

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	892,687,783.90	543,977,865.59	436,425,541.17	1,873,091,190.66
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	892,687,783.90	543,977,865.59	436,425,541.17	1,873,091,190.66
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн			-38,957,186.23	-38,957,186.23
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	892,687,783.90	543,977,865.59	397,468,354.94	1,834,134,004.43
D01	2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	892,687,783.90	543,977,865.59	397,468,354.94	1,834,134,004.43
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	892,687,783.90	543,977,865.59	397,468,354.94	1,834,134,004.43
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00		-22,344,534.00	-22,344,534.00
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	892,687,783.90	543,977,865.59	375,123,8520.94	1,811,789,470.43

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ЭЗА	Үзүүлэлт	Тайлант оны		
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	803,518,800	802,216,757.85	1,302,042.15
21	УРСГАЛ ЗАРДАЛ	803,518,800	802,216,757.85	1,302,042.15
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	800,528,800	799,406,757.85	1,122,042.15
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	568,915,500	568,871,785.99	43,714.01
210101	Үндсэн цалин	377,849,400	367,162,519.39	10,686,880.61
210102	Нэмэгдэл	188,126,100	188,862,235.6	-736,135.60
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,260,000	11,167,031	-9,907,031.00
210104	Урамшуулал	1,680,000	1,680,000	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	13,756,900	13,756,900	0.00
210205	Эрүүл мэндийн даатгал	13,756,900	13,756,900	0.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	119,507,400	119,449,995.86	57,404.14
210301	Гэрэл, цахилгаан	17,540,100	15,504,362.86	2,035,737.14
210302	Түлш, халаалт	77,777,100	79,751,860	-1,974,760.00
210303	Цэвэр, бохир ус	24,190,200	24,193,773	-3,573.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,101,900	21,095,000	6,900.00
210401	Бичиг хэрэг	2,679,900	2,679,900	0.00
210402	Тээвэр, шатахуун	12,850,400	12,850,400	0.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,503,400	3,503,400	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	308,000	301,100	6,900.00
2105406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,760,200	1,760,200	0.00
2105	Нормативт зардал	30,730,600	29,793,973	936,627.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	859,900	859,900	0.00
210502	Хоол, хүнс	29,870,700	28,934,073	936,627.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	33,518,000	33,518,000	0.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,570,700	8,570,700	0.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	155,900	155,900	0.00
210604	Урсгал засвар	24,791,400	24,791,400	0.00
2107	Томилолт, зочны зардал	1,348,000	1,310,600	37,400.00
210702	Дотоод албан томилолт	1,348,000	1,310,600	37,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,650,400	11,610,503	39,897.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,892,000	8,853,700	38,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000	432,000	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	280,000	279,913	87.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	50,500	50,500	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	818,500	818,500	0.00
210807	Газрын төлбөр	1,177,400	1,175,890	1,510.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,990,000	2,810,000	180,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,990,000	2,810,000	180,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,990,000	2,810,000	180,000.00

III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	803,518,800	803,974,657.85	-455,857.85
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	788,876,300	788,472,757.85	403,542.15
310001	Улсын төсвөөс санхүүжих	788,876,300	788,472,757.85	403,542.15
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	14,642,500	15,501,900	-859,400.00
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,791,400	6,892,900	898,500.00
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,851,100	8,609,000	-1,757,900.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь шүүхээс гарсан шийдвэрийг нэг мөр ханган биелүүлэх хууль сахиулах үйл ажиллагааг явуулдаг байгууллага юм.

Увс аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга-Төсвийн төвлөрүүлэн захирагчтай 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 4 зорилтын хүрээнд 42 багц ажил үйлчилгээг хэрэгжүүлэхээр тусгаж газрын тасаг, нэгж бүрээр дэд төлөвлөгөөг баталж, холбогдох албан тушаалтнуудыг өдөр тутмын мэргэжил, арга зүйгээр ханган ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Хорих байгууллага дахь хүний эрхийн тухай ойлголт, түүнийг хангах чиглэлээр батлагдсан олон улсын гэрээ конвенц, "Жендер" сэдвийн сургалтад бүх алба хаагчдыг хамруулсан ба хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа хариуцсан шийдвэр гүйцэтгэгчийн орон тоонд эмэгтэй алба хаагчийг томилуулан ажиллаж байна.

Тайлант хугацаанд санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөрийн тухай хууль - Шинэчлэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль -2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан.
- ✓ Төрийн албаны тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 05-ны өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр нэмэлт өөрчлөлтүүд оруулсан байна.
- ✓ Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 01-ний өдөр, 8 дугаар сарын 29-ний өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр
- ✓ Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам"
- ✓ Засгийн газрын 2019 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 276 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт
- ✓ Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолын 7 дугаар хавсралт
- ✓ Сангийн сайдын 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 120 дугаар "Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай" тушаалд тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Увс аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Увс аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж болон, нягтлан бодох бүртгэлийн стандарт бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 22,344.5 мянган төгрөгөөр буюу 1.2 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	128.0	128.0	0.0
Авлага	0.0	0.0	0.0
Бараа материал	62,304.6	60,593.6	-1,711.0
Үндсэн хөрөнгө	1,771,701.4	1,751,067.9	-20,633.5
Нийт хөрөнгө	1,834,134.0	1,811,789.5	-22,344.5
Өр төлбөр	0.0	0.0	0.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,834,134.0	1,811,789.5	-22,344.5
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,834,134.0	1,811,789.5	-22,344.5

Мөнгөн хөрөнгийн данс 128.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 60,593.6 мянган төгрөг болж 1,711.0 мянган төгрөгөөр буурсан нь сэлбэг хэрэгсэл, бичиг хэрэг, бусад хангамжийн материалын зарцуулалтаас шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй.

Үндсэн хөрөнгийн данс нь 1,751,067.9 мянган төгрөг болж 20,633.5 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 6,705.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч, тайлант онд 74,288.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал тооцсон, 64,550.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 43,402.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 3,830.3 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 5,110.0 мянган төгрөгийн програм хангамж акталж данснаас хассантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,811,789.5 мянган төгрөг болж 22,344.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн буурсантай холбоотой байна.

Тайлант онд авлага, өр төлбөр үүсээгүй байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Увс аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 847,074.6 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 847,074.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 135,305.7 мянган төгрөгөөр бууруулж 711,768.9 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулиас шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг тодотголоор 77,107.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 788,876.3 мянган төгрөгөөр баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 788,876.3 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна. Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 786,714.9 мянган төгрөг буюу 98.2 хувьтай байгаа нь үйл ажиллагааны зардлын төсвийг 2,161.4 мянган төгрөг дутуу зарцуулсантай холбоотой байна. Шүүхийн шийдвэрийн үйлдвэрлэл, туслах үйл ажиллагааны зардал арга хэмжээний төсвийн зарцуулах эрх оны төгсгөлд нээгдээгүйн улмаас зарцуулаагүй төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70705-Шүүхийн шийдвэр гүйцэтгэл 80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	769,670.6	769,484.5	186.1	99,9%
2	80102-Туслах үйл ажиллагааны зардал	13,718.4	12,859.0	859.4	93,7%
3	80103-Гэрээгээр гүйцэтгэх ажил үйлчилгээ	9,599.3	9,599.3	0	100%
4	80229-Шийдвэр гүйцэтгэлийн үйлчилгээ	6,616.4	6,579.0	37.4	99,4%
5	80235-Шүүхийн шийдвэрийн үйлдвэрлэл	1,783.5	885.0	898.5	49,6%
6	80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	2,990.0	2,810.0	180.0	93,9%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Увс аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын нэмэлт санхүүжилтийн дансанд Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс 2,500.0 мянга, дээд

шатны төсвийн захирагчаас 6,505.6 мянга, нийт 9,005.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, 8,970.6 мянган төгрөгийг зарцуулж, 35.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Увс аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Одгэрэл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Увс аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01/96 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 6.8 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Гүйцэтгэлийн үе шатанд 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 889.2 сая төгрөгийн 1.0 хувь буюу 8.9 сая төгрөгөөс 80 хувиар тооцож 7.1 сая төгрөгөөр тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллагад хамаарах зүйл заалтын хүрээнд биет горим сорилыг хэрэгжүүлсэн. /АБ-4/

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа 141, хугацаа хоцроосон 8 мэдээллийг байршуулсан, хугацаа болоогүй 2 мэдээлэл хүлээгдэж байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хэрэгжилт

Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсэгт “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэж заасныг Увс аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь тайлант хугацаанд бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Увс аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийхэд зөрчил илрээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлага, зөвлөмж байхгүй.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарч үзэх чухал асуудал байхгүй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа зөрчил илрээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М.БАТСУУРЫ/


АУДИТЫН МЕНЕЖЕР

/М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

/Б.ОДГЭРЭЛ/



2023 оны 02 сарын 09-ний өдөр